



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	
Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-17

1. Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	4-12
2. Хуулийн төслийг эцэслэн батлах	12-13
3. Баталсан хуулийн эцсийн найруулга сонсох	13-16

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 13-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Р.Эрдэнэбүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга,
Д.Бум-Очир, С.Ганбаатар, Д.Ганбат, М.Ганхүлэг, С.Лүндэг, П.Сайнзориг,
Д.Үүрийнтуяа;
Чөлөөтэй: О.Номинчимэг, Л.Оюун-Эрдэнэ, О.Саранчулуун, Ж.Чинбүрэн;
Тасалсан: Н.Алтанхуяг, Б.Батбаатар, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн,
Т.Доржханд, Б.Жавхлан, З.Мэндсайхан, Д.Цогтбаатар;
Хоцорсон: О.Алтангэрэл- 01 минут, Н.Алтаншагай- 19 минут,
С.Амарсайхан- 09 минут, Ч.Анар- 03 минут, Т.Аубакир- 25 минут, Ц.Баатархүү-
30 минут, Д.Батбаяр- 06 минут, Р.Батболд- 03 минут, П.Батчимэг- 04 минут,
Ж.Бат-Эрдэнэ- 11 минут, Ж.Баясгалан- 38 минут, Х.Болормаа- 02 минут,
Э.Болормаа- 07 минут, Х.Булгантуяа- 14 минут, Ш.Бямбасүрэн- 08 минут,
А.Ганбаатар- 01 минут, П.Ганзориг- 03 минут, Д.Ганмаа- 01 минут, Б.Жаргалан-
09 минут, Д.Жаргалсайхан- 42 минут, Б.Заяабал- 23 минут, Ж.Золжаргал- 04
минут, Ц.Мөнхтуяа- 02 минут, Н.Наранбаатар- 03 минут, Ч.Номин- 01 минут,
С.Одонтуяа- 15 минут, Б.Пунсалмаа- 39 минут, Б.Түвшин- 06 минут, Х.Тэмүүжин-
13 минут, Ч.Ундрам- 07 минут, Б.Чойжилсүрэн- 18 минут, Л.Энх-Амгалан- 15
минут, Ж.Энхбаяр- 31 минут, Д.Энхтуяа- 02 минут, Д.Энхтүвшин- 06 минут,
С.Эрдэнэбат- 05 минут.

**Нэг.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг
дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Баасанжаргал, Ө.Шижир, Л.Мөнхбаатар, Б.Түвшин нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 10 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Төрийн байгуулалтын байнгын хороо Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангаж, Улсын Их Хурлын гишүүдэд төслийн хувилбарыг тараасан тул эцэслэн батлах санал хураалт явуулах талаар хэлэв.

Хоёр.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80

Татгалзсан: 17

Бүгд: 97

82.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Б.Батцэцэг, О.Батнайрамдал, О.Алтангэрэл, Ж.Бат-Эрдэнэ, Б.Батболд нарын санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 97 гишүүнээс 86 гишүүн дэмжиж, 88.7 хувийн саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ энэ өдрийн нэгдсэн хуралдаанаар Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг сонсох санал гаргав./10:35/

Гурав.Баталсан хуулийн эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны референт А.Наранцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав.

Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, А.Амгаланбаатар, Б.Пүрэвдорж, Г.Дамдинням нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:45/

Уг асуудлыг 10 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 42 минут үргэлжилж, 126 гишүүнээс 102 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 05 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Ирц хүрсэн тул чуулганы хуралдааныг эхлүүлье.

2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэнэ.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрөөтэй саналыг Улс төрийн намын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох зүйлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд, зарчмын зөрөөтэй санал болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Улс төрийн намын тухай хууль түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Д.Амарбаясгалан: Мөнхбаатар гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулъя.

Ням-Осорын Учрал ЗГХЭГ-ын дарга, Баярсайханы Солонгоо ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нийт 4 гишүүн нэр ирүүлсэн байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжих хугацааг миний, би 2026 оны 01 сарын 01 гэсэн боловч ажлын хэсгийн 2025 оны 12 сарын 31 хүртэл гэдэг энэ заалтаар дэмжигдэж санал хураагдаж явж байгаа.

Тэгэхээр “хүртэл” гэдэг хугацаа бол он гараад л эхэлнэ гэсэн үг байхгүй юу даа. Он гараад эхэлнэ гэсэн үг. Тэгэхээр энэ он гараад эхэлнэ гэдэг чинь бас энэ тийм, асуудалтай намуудын хувьд тийм бужигнаан үүсэх, тийм нөхцөл байдлыг бий болгож байгаа. Тэгээд энэ Засгийн газрын тогтвортой байдалд бас тодорхой хэмжээгээр нөлөөлнө өө гэж би хараад байгаа юм. Яагаад гэвэл энэ хамтарсан Засгийн газар бол томоохон том том хүсэл төслүүдийг хөдөлгөх нь их чухал юм гэдэг нь ойрын үед бас харагдаад байгаа. Төсвийн хэлэлцүүлэг дээр харагдаж байна.

Дээрээс нь Цөмийн энергийн хууль, үүнийг дагалдаж орж ирэх Бадрах Энержи болон хил холболтын Чайна Энержи зэрэг олон олон асуудлуудыг шийдвэрлэснээр энэ эдийн засагт чухал арга хэмжээг хэрэгжүүлэх, Монголын эдийн засагт өсөлт авчрах ийм том том төслүүдийг хэрэгжүүлснээрээ маш чухал ач холбогдолтой гэж харж байгаа. Тэгэхээр энэ “хүртэл” гэснээр асуудал өрнөх вий гэдэг дээр би бас санаа зовж энэ намын тухай хуулийн хэрэгжсэнээр бас тодорхой Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орох зарим нэгэн асуудал үүсэх ийм нөхцөл байдал руу очих юм.

Тийм учраас хамгийн наад захдаа жишээ нь СЕХ-ны оруулж ирсэн 2025 оны 08 сарын 01 гэдгийг яагаад аваагүй юм бэ гэхээр аль болох л энэ он руу дөхүүлнэ гэсэн л ийм л агуулгаар л энэ 2025 оны 12 сарын 31-нийг хүртэл гэдэг агуулга орж ирж байгаа шүү гэдгийг бас энэ протоколд тэмдэглүүлж хэлмээр байгаа юм.

Тэгээд энийг дагуулаад бас тодорхой хэмжээний хамтарсан гэгчхээд, энэ Пүрэвдорж хамтарсныг дэмжээд байгаа нь гэсэн мөртөө, шууд бүгд тэр утгаар нь шууд ойлгож болохгүй. Яагаад гэвэл хамтарсан гэгчхээд тийм тодорхой хэмжээний хамт асуудал дээр хамтрахгүй. Ялангуяа өчнөөн олон жил 8 жилийн туршид энэ хулгай зэлгийг хийсэн тэр нөхдийг солих арга хэмжээг хийхгүй. Ялангуяа төрийн өмчийн томоохон компаниуд дээр маш том том хулгайнууд явдаг. Тэр хулгайнуудыг

цэгцлэхгүй. Тэнд ажиллаж байгаа хүмүүс үргэлжлүүлэн яг урд байсан тэр нөхцөл байдлаараа асуудалд ханддаг. Ийм нөхцөл зүйлүүд хэвээрээ байгаад байна.

Тийм учраас энэ дээр бас жоохон энэ Засгийн газар, ялангуяа төрийн өмчийн компаниуд болон энэ яамнуудын дунд шатан дээрээ болж байгаа тэр томилгоонууд дээр бас тодорхой хэмжээгээр анхаарлаа хандуулж ажиллах ёстой шүү гэдгийг бас анхааруулж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Х.Баасанжаргал: Би нэг 3 асуулт асуугаадахъя. Тэгээд үг хэлэх чинь дахиад тусдаа байгаа бил үү, дарга аа, энүүгээрээ юу, тусдаа байхгүй юм уу тийм ээ. Тэгвэл үгтэйгээ хамт хэлье.

1 дүгээрт, улс төрийн намын энэ хугацаа хойшлуулснаар үүсэх үр дагавартай холбоотой юмыг асуугаадахъя. 08 сарын 01-нээс өмнө улс төрийн намууд санхүүжилтийг авах, төрөөс үзүүлэх дэмжлэг, дэмжлэгээ авах тухай хүсэлтээ өгсөн байх ёстой. Одоогийн байдлаар хуулиараа бол. Тэгэхээр яг энэ хуульд заасны дагуу хүсэлтээ өгсөн хэчнээн улс төрийн нам байгаа вэ?

Дээрээс нь эдгээр хүсэлт өгсөн улс төрийн намууд дотроос яг энэ нөгөө өнөөдрийн энэ хугацаандаа багтаад дүрмээ шинэчилчихсэн, тийм улс төрийн нам одоогоороо байгаа юу гэдэг 1 асуулт.

2 дугаарт, яг хуулийн төсөл дээр нэг ийм зүйл орж ирж байна. Өмнөх хэлэлцүүлэг дээр орж ирээгүй. 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор гээд. Дээрээс нь уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ ээ гэхээр 12 сарын 31-нээс хойш 1 сарын 30 гэдэг хугацаа орж ирж байна уу гэж ойлгох уу гэдэг ийм 2 асуулт асуугаадахъя.

Тэгээд эцэст нь яах вэ, улс төрийн нам бол өөрөө энэ ардчиллын хамгийн гол суурь институт. Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хамгийн зохион байгуулалттайгаар илэрхийлдэг маш чухал хариуцлагатай институтууд байгаа. Тэгэхээр эдгээр институцийн үйл ажиллагаа маш хариуцлагатай байж гэмээ нь, өнөөдөр иргэдийн төрд итгэх итгэлийг өсгөхөд асар их чухал үүрэгтэй. Тийм учраас дахиж энэ хугацааг хойшлуулах талаар санал орж ирэхгүй байх гэж бусад улс төрийн намаас бас найдаж байна. Тэгэхээр энэ дээр маш их хариуцлагатай хандаасай гэж бусад улс төрийн намуудыг бас уриалах байна.

Дээрээс нь энэ Улс төрийн намын тухай хуулийн хамгийн гол бас томоохон өөрчлөлтийн нэг зүйл бол эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлсэн ийм бүтцийн маш том өөрчлөлт оруулсан байгаа. Үүнийгээ бас хийнэ гэж найдаж байна гээд. Ингээд энэ 2 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Хэн хариулах вэ? Ням-Осорын Учрал ЗГХЭГ-ын дарга хариулт өгье.

Н.Учрал: Улс төрийн намын хууль хэрэгжээд эхэлсэн байгаа. Өнөөдөр бид зөвхөн Улс төрийн намын хуулийг дагаж мөрдөх журмын хууль дээр заасан 5

зүйлийн 2 дугаар зүйл. 2 дугаар зүйл дээр зөвхөн дүрмийг шинэчилж бүртгүүлээд, намын бүх гишүүдээр хэлэлцүүлээд, дүрмээ шинээр Улсын дээд шүүхэд өгөөд, Улс төрийн намын хууль шинээр бүртгүүлэх тэр дүрмээ бүртгүүлэх хугацаан дээр л сунгалтыг ярьж байгаа. Тэрнээс биш Баасанжаргал гишүүний хэлж байгаа бусад тэр санхүүжилттэй холбоотой, дээрээс нь тэр ил тод байлгахтай холбоотой, улс төрийн намын санхүүжилтийг олон нийтэд бас ил тод байлгахтай холбоотой, Улс төрийн намын хуулийн бүхий л заалтууд бол хэрэгжээд эхэлсэн. Тэгэхээр энэ Улс төрийн намын хуулийг хэрэгжүүлэх үүрэг нь улс төрийн намуудад хадгалагдаж байгаа.

Яг өнөөдрийн байдлаар Улсын дээд шүүхэд 7 улс төрийн нам дүрмээ шинэчилж бүртгүүлэх хүсэлтээ хүргүүлсэн. Гэхдээ дүрэм нь шинэ хуульд нийцэж байгаа эсэх дээр эцсийн дүгнэлт гараагүй. Улс төрийн намын энэ шинэ хуулиар энэ санхүүжилттэй холбоотой, дээрээс нь тэр гишүүнчлэлтэй холбоотой, ялангуяа нөгөө жендертэй холбоотой буюу улс төрийн намын анхан шатанд болоод удирдах дээд байгууллага, бүх түвшинд 40 хувийн жендерийг заавал барих ийм шаардлагууд бас бүрэн хангагдсан эсэх дээр эцсийн дүгнэлт гараагүй.

Тэгэхээр энэ 7 улс төрийн нам, хүсэлтээ ирүүлсэн намууд яг шинэ хуулийг чанд баримтлаад энэ хуульд нийцүүлсэн дүрмээ барьсан эсэх дээр эцсийн дүгнэлт гараагүй учраас бүгдээрээ шинэ дүрмээр бүртгүүлнэ ээ гэдэг ийм баталгаа байхгүй. Нийтдээ өнөөдрийн байдлаар нэг 12 улс төрийн намаас Засгийн газарт мөн Засгийн газрыг бүрдүүлж байгаа 3 улс төрийн намын дарга нарт бас хүсэлтээ ирүүлсэн. Тодорхой хугацаа өгч дүрмээ шинээр бүртгүүлэх дээр боломж олгооч ээ гэдэг. Гэхдээ бид нэг зүйлийг барьж байгаа нь юу вэ гэвэл нэгэнт хэрэгжсэн Улс төрийн намын хуулиа барина. Та нар санхүүжилтээ ил тод болго оо, энэ жендерийг барих, энэ улс төрийн намын хатуу гишүүнчлэл энэ дэмжигч гишүүд гэдэг ойлголттой статусыг илүү ойлгомжтой болго гэдгийг шаардаж байгаа.

Ер нь улс төрийн намууд энэ хэрэгжээд эхэлсэн хуулийг чанд барих ёстой. Ингээд өөрсдөөсөө хариуцлагыг эхлэх ёстой. Цаашдаа дахиж сунгах ойлголт байж ерөөсөө болохгүй. Тийм учраас энэ хугацаандаа улс төрийн намууд хариуцлагатай байж, хурал зөвлөгөөнүүдээ хийж, шинэ хуулиа чанд хэрэгжүүл ээ гэдэг шахалт шаардлагыг байнга бид тавих ёстой. Ингээд 12 дугаар сарын 31 гэж ажлын хэсгээс оруулж ирсэн санал дэмжигдвэл, 12 сарын 31-нд сунгах энэ хугацаа хэрэгжээд эхэлсний дараа 1 сарын дотор бүх бүртгэл Улсын дээд шүүхэд ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Бүгдэд нь өглөөний мэнд.

1 дүгээрт, Их Хурлын дарга аа, би одоогоос яг 1 сарын өмнө Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад хандаад, бид нар энэ хэл ам дагуулаад байгаа төхөөрөмжтэй холбоотой яг ямар компани, хэдий хугацаанд, хэдэн төгрөгөөр нийлүүлсэн юм бэ гээд бичиг явсан. Өнөөдөр өгөөгүй байна. Тэгээд хэдүүлээ өнгөрсөн 5 сард яг үнэнийг хэлэхэд санал хураах өдөр болгон энэ төхөөрөмж яриад байгаа. Тэгээд энэ төхөөрөмжийнхөө асуудлыг нэг талд нь гаргаад, ингээд ойлгомжтой байдал руу оруулахгүй бол ингээд санал хураалт болгонд ийм тодорхойгүй байдлууд үүсээд байна. Тэгээд надад энэ бичгийг одоо яг өнөөдөр нэг сар нь. Тэгээд бичгийг өгүүлэх тал дээр нэг анхаараад өгөөч.

Хоёрдугаарх нь, энэ Улс төрийн намын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2023 онд хэлэлцэж байх үед энэ манай Их Хурлын гишүүдийн яриад байгаа асуудлуудыг тухайн үеийн хэлэлцүүлгүүд бүгд ярьж байсан юм байна лээ. Одоо жишээ нь, манай энэ Ганбат гишүүн, Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүн бол яг энэ протокол дээр нь уншихад юу гэж асууж байсан юм бэ гэхээр парламентад суудалгүй улс төрийн намууд энэ хуульд тодорхой хэмжээний эсэргүүцэл илэрхийлж байна. Тийм учраас энэ парламентад суудалгүй байгаа улс төрийн намуудаас ямар саналуудыг нь авсан бэ гэж ийм асуулт асуусан байна лээ. Тэгээд түүн дээр тухайн үеийн ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн гишүүн бол парламентад суудалтай улс төрийн бүх намуудтай бид нар, ажил улсын хэсэг, Байнгын хорооны хүрээнд 2 удаа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэ уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах хүрээнд бид нар бүх саналуудыг нь хүлээж авсан. СЕХ бүх материалд хяналт тавьж, энэ өнөөдөр хийгээд саналуудыг нь хүлээж аваад, одоо энэ Улс төрийн намын тухай хууль дээр бид нар нэг ойлголцолд хүрсэн гэсэн ийм хариулт өгсөн байна лээ.

Тэгтэл одоо энэ Улсын дээд шүүхэд үндсэн дүрэм өөрчлөлт оруулаад, хуулийн хугацаанд бичиг баримт материалаа бүрдүүлсэн 7 нам, хойшлуулахыг хүссэн ингээд 5 нам байгаад байдаг. Тэгээд 5 намыг нь ингээд харахаар яг ний нуугүй хэлэхэд өдөр болгон эсвэл байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүй, зөвхөн сонгуулийн үеэр идэвхэждэг тийм намууд байгаад байгаа. Та хэд бүгдээрээ мэднэ. Одоо сонгуулийн үеэр тухайн намаасаа, нам эвслээсээ нэр дэвших квотоо авч чадаагүй бол нөгөө намаас нь очоод тэр тойрогт нэр дэвшчихдэг, эсвэл адилхан нэртэй хүнийг бас дэвшүүлчихдэг гэдэг ийм технологиуд байгаад байдаг. Тэгээд эдгээр ийм юмнуудыг хийдэг намууд ингээд дахиад хойшлуулах хүсэлт тавьчихсан байна л даа. Тэгээд энэ одоо заасан энэ хуулийн хугацаанд дахиад энэ намууд ийм хүсэлт тавивал яах вэ гэдэг ийм асуулт байна. Тэгэхээр бид нар энэ дээр ямар асуудал барих юм бэ гээд.

Д.Амарбаясгалан: Шижир гишүүний тэр бичгийн хариуг Баасандорж дарга албан ёсоор бас өгөх хэрэгтэй байх. Энэ Их Хурлын систем чинь өөрөө төрийн нууцын мэдэлд байдаг юм байна лээ, тагнуулын байгууллагын хяналтад. Тэгэхээр нөгөө энэтэй холбоотой мэдээллийг би ч танилцах эрхгүйгээр л байж байгаа. Ер нь өнгөрсөн жил захиалсан систем. Системийн хувьд, төхөөрөмжийн хувьд энэ өөрөө дэлхийн маш олон улсын хэрэглэдэг систем гэдэг ийм мэдээллийг бидэнд өгсөн байгаа. Зүгээр бидэн дээр үүсээд байгаа асуудал Шижир гишүүн ийм юм байгаа юм. Хурууны хээг уншиж байгаа төхөөрөмж хурууны хээ 2-ыг 100 хувь таарахаар тохируулга хийгдчихсэн юм байна лээ. 100 хувь. Манай иргэд сонгуульд орохдоо хурууны хээгээ уншуулж байгаа шүү дээ. Тэр өөрөө 65-70 хувийн юу гэдэг юм нөгөө таарах тэр нөхцөлийг нь бүрдүүлчихсэн байдаг юм байна. Тэгэхээр манай гишүүдийнх яг 100 хувийн хурууны хээ таарах ёстой гэсэн ийм тохируулгатай байгаа. Зүгээр энэ дээр бид бас холбогдох байгууллагатай нь яриад, энэ 100 хувийг тодорхой хэмжээгээр бууруулах боломж байгаа эсэх дээр судалгаа явуулж байна.

Тэгэхээр нөгөө сонгуульд санал өгөхдөө иргэдийн уншуулдаг яг тэр төхөөрөмжтэй адилхан, магадгүй 70 хувиар тараад уншчих тийм боломж нөхцөлүүд нь байна уу, үгүй юү гэдэг дээр судалгааны ажил холбогдох мэргэжлийн байгууллага дээр явагдаж байгаа гэдгийг бас тайлбарлаад хэлчихье.

Тэгэхээр нөгөө гишүүд маань зарим үед яаран сандран хазгай дутуу дарснаас болж үүсээд байгаа асуудлыг тодорхой хувиар бууруулах тийм алхам байж болох

уу гэдэг л ийм байдлаар судалгаа хийгдэж байгаа гэдгийг бас тайлбарлаад хэлчихье.

Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Тэгээд хэрвээ тэр нь нууцтай холбоотой юм бол нууцаар авъя, мэдээллээ. Ер нь өнгөрсөн 5 сарын хугацаанд миний төхөөрөмжийн хувьд 1 ч удаа ажиллаагүй, эсвэл хурууны таниагүй ийм тохиолдол үүсээгүй. Тийм учраас би энэ төхөөрөмжийг 100 хувь ажиллаж байгаа гэдэгт бүрэн итгэлтэй байгаа. Тэгээд саяын тэр Улс төрийн намын тухай хуулийн юун дээр ажлын хэсгийн даргаас асуусан асуултад хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Болох байх. Тэгээд Баасандорж дарга тэгээд Шижир гишүүнд холбогдох танилцуулгуудыг энэ тагнуулын байгууллагатай холбогдоод, бас мэргэжлийн байгууллагатай нь холбогдоод, үзүүлж харуулаад, судлуулаад явчих нь зүйтэй байх гэж бодож байна.

Учрал сайд тодруулж нэмэлт хариулт өгье.

Н.Учрал: Улс төрийн намын хуулийн дагаж мөрдөх хугацаа 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс эхэлсэн. Дагаж мөрдөх хугацаатай холбоотой биш дагаж мөрдөх хугацаанаас гадна нөхцөлийг хангуулах, үүрэгжүүлэх зохицуулалт дагаж мөрдөх журмын хуульд хамаардаг. Тэгээд дагаж мөрдөх журмын хуулийн 2 дугаар зүйл нөгөө дүрмийг шинээр бүртгүүлэх хугацаан дээр сунгалт орж байгаа учраас Улс төрийн намын хуулиар улс төрийн намыг үүрэгжүүлсэн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа.

Тэгэхээр энэ заалтуудаа бүрэн хангуулаад, энэ шинэчилсэн дүрмээ одоо энэ ажлын хэсэг дээр яригдаад 12 сарын 31-нээс энэ сунгалтын хугацаа хэрэгжээд эхэлсний дараа цаг хугацаандаа дүрмийг хангуулж өгөхгүй тохиолдолд энэ улс төрийн намуудыг бүртгэх, шинээр бүртгэхгүй гэсэн үг. Тэгэхээр ингээд улс төрийн намууд хариуцлагатай байх ёстой. Энэ цаг хугацаанаас хойш дахиж тэр дүрмийг шинэчлэн бүртгэх ойлголт огт байхгүй.

Д.Амарбаясгалан: Лхагвын Мөнхбаатар гишүүн үг хэлье. Асуулт асууя.

Л.Мөнхбаатар: Улс төрийн нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтаа Улс төрийн намын хууль, холбогдох хууль тогтоомжид нийцүүлээд Улсын дээд шүүхэд бүртгүүлэх ийм үүргийг 01 сарын 01-нээс өмнө авч хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн. Энэ хуулийн хэрэгжүүлэх явцад парламентад суудалгүй намуудаас бас тодорхой шаардлага тавьж, энэ хугацааг сунгаж өгөхийг хүссэн. Ингээд нэг жилийн хугацаатай ингээд сунгаж байна. 2025 оны 12 сарын 31-нээс өмнө бүх намууд дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтаа бүртгүүлэх нь ээ. Энэ хугацааг бас ингээд олонтоо сунгаж байхад бас гишүүд бас нэлээн эргэлзэж, бас юу асууж байна лээ. Дахин дахин ингээд сунгаад яваад байх нь хэр зохимжтой вэ гэдэг талаас нь харж байна лээ. Ер нь энэ дээр дахин сунгахгүй байх нь зүйтэй. Нэг жилээр сунгаж байгаа.

Үүнээс гадна энэ хуульд бас заасан бас нэг хугацаатай асуудал байгаа. Энэ дагаж мөрдөх журмын тухай хууль дээр. Энэ бол 2028 оны 01 сарын 01-нээс өмнө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд зааснаар сонгуулийн эрх бүхий иргэдийн 1

хувиас доошгүй иргэд эвлэлдэн нэгдэж байж нам байгуулна, намын үйл ажиллагаа явуулна. Тийм. Энэ нь одоогийн статистикаар нэг 22000 орчим иргэн нэгдэж байж нам болно гэсэн үг. Тэгэхээр энэ босгыг давсан энэ намууд л улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах, улс төрийн үйл ажиллагаа явуулах ийм боломжтой болно.

Тэгэхээр энэ хугацаанд энэ Улсын дээд шүүхэд бүртгэлтэй байгаа 37 нам маань энэ бэлтгэлийг хангахгүй бол мөн ахиад 28 оноос өмнө бас энэ хугацаагаа сунгах гээд зогсож байх вий. Тийм учраас энэ асуудлаа эртнээс бэлтгэлийг хангах талаас нь бас их нэлээн анхаарах хэрэгтэй байна.

2 дугаарт, бас хэд хэдэн шаардлагууд бий. 2 болон түүнээс дээш сонгуульд оролцоогүй нь намыг идэвхгүйд тооцдог. Түүнээс гадна намын удирдах байгууллага, төлөөллийн төв байгууллагаа 5 жил хуралдуулаагүй бол бас идэвхгүйд тооцно. Энэ мэтчилэн их олон шаардлагууд байгаад байгаа. Ингэхээр эдгээр шаардлагыг давж гарч ирсэн л намууд улс төрийн үйл ажиллагаа явж, ард иргэдийн дэмжлэг авч ажиллана. Тийм болохоор энэ хуулийн хугацааг бүрэн баримталж ажиллах хэрэгтэй гэж би бодож байгаа юм.

Нөгөөдхөөр Төрийн байгуулалтын байнгын хороо бас энэ хаврын чуулганаар энэ улс төрийн намын хэрэгжилттэй холбоотой асуудлыг ер нь нэг сонсох нь зүйтэй байх. Тэгж байж бас энэ улс төрийн намууд институцийнхээ хувьд бэхжих энэ бололцоонд нь бас тодорхой дэмжлэг үзүүлж ажиллах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаагаа хэлье.

Д.Амарбаясгалан: Үг байхгүй. Эцсийн хэлэлцүүлэг. Асуулт, хариулт.

Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууна.

Б.Түвшин: Баярлалаа. Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ Улс төрийн намуудын тухай хуулийг ярьж байгаа дээр нэг хэд хэдэн санааг бас хэлье гэж бодсон юм. Зүгээр ер нь бол төрөө цэвэршүүлэх үндэслэл бол энэ улс төрийн намуудын төлөвлөөс хамаарна л даа. Тэгээд 30 гаруйхан жил ингээд олон ургалч үзэлтэй, олон талын намууд ингээд төлөвшөөд өнөөдрийг хүрч байна. Өнөөдрийн байдлаар ер нь харьцангуй энэ төлөвшил тал руугаа явуулаад, тэгээд үүнийгээ төлөвшлийг нь баталгаажуулах, улам цааш нь төлөвшилтэй улс төрийн чиг баримжаатай, мафижсан хэлбэрээс нь салгуульа гээд ингээд Улс төрийн намын тухай хууль батлагдаад явж байгаа нь нэг талаасаа сайшаалтай зүйл.

Ер нь тэгээд яах вэ, улс төрийн намууд өөрөө төлөвшиж байж л төр цэвэрших учраас энэ намуудын үзэл баримтлал, намуудын зохион байгуулалтууд, намуудын явуулж байгаа бодлого, арга хэмжээ дээр бид нар зайлшгүй төлөвшүүлэх бодлогуудыг явуулах хэрэгтэй байгаад байгаа юм. Зүгээр өнгөрсөн хугацаанд бид нарт аль аль намуудад алдаа, оноонууд их байсан. Тэгээд энэ алдаа оноонуудаас дурдах юм бол ямар нэгэн үзэл баримтлалгүйгээр, тодорхой бүлэг фракцууд болж явуулдаг. Хэтэрхий төрийг барихын тулд намыг ашигладаг, урт хугацааны хурлаа хийхгүй байдлаасаа болж, эс үгүй бол аль нэг нь нөгөөдхийгөө гацаах замаар ингээд төрийн үйл ажиллагаа явуулах, намуудын үйл ажиллагаа явуулах боломжуудыг хязгаарладаг. Энэ бүхнийг хязгаарлахаар ингээд Улс төрийн намуудын тухай хууль орж ирсэн гэж үзэж байгаа.

Өнөөдөр энэ бүртгэлийг хойшлуулъя гэж тавьж байгаа намууд маань гэтэл өөрөө бас төлөвшсөн намууд мөн үү, биш үү гэдэг асуудал бас яригдах ёстой. Ер нь ямар намуудыг улс төрийн намууд гэх юм бэ? Ямар зохион байгуулалт хийж байгаа намуудыг төлөвшсөн нам гэж үзэх юм бэ? Улс төрийн хүчин болоход яг бэлэн байгаа юм уу, эс үгүй бол нэг хэсэг бүлэг хэдхэн хүмүүсийн ашиг сонирхлоор хөдлөөд байгаа улс төрийн нам, улс төрийн институтийн нэрийг ашиглаж, хуулийн цоорхойг ашиглаж явж байгаа ийм байгууллагууд уу гэдгийг ер нь яаж задалж, яаж төлөвшүүлж харах юм бэ? Өнгөрсөн хугацаанд төлөвшөөгүй байсан ч гэсэн өнөөдөр төлөвшсөн гэдэг нэрийн доор явж байгаа боловч энэ хурлаа хийхгүй хойшлуулаад байгаа үйл явц нь өөрөө дахиад намын удирдлага эрх мэдлүүд бас тодорхой өөр ашиг сонирхолтой байхыг үгүйсгэхгүй байгаад байгаа юм.

Тийм учраас намын төлөвшлийн асуудлууд дээр нэг цааш нь энийг зөв хүчин болгох, ялангуяа энэ геополитикийн байдал ийм эвгүй байж байгаа үед энэ улс орны үндэсний эрх ашгийг хамгаалах, улс орныг задлан бутаргачихгүй байх, ямар нэгэн бүлэглэл мафиуд дээр нь гарчихгүй байх тухай намын төлөвшлийн асуудлуудыг ямархуу бодлогоор авч явъя гэж бодож байна. Энэ улс төрийн намын хуулийн хэрэгжилтийг хойшлуулъя гээд байгаа намуудын төлөвшил өөрөө яг болж байна уу, улс төрийн бодитой үзэл баримтлалтай байж чадаж байна уу. Яг ямархуу улс төрийн үйл ажиллагаа явуулдаг, явуулах сонирхолтой, ямархуу зохион байгуулалттай институцүүд энэ хуулийг хойшлуулъя гэж хүсээд байгаа юм бэ гэдэг талаар товчхон мэдээлэл өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Тийм, энэ Түвшин гишүүний ярьж байгаа зүйл бол маш зөв л дөө. Энэ улс төрийн олон нам байна. Тэгээд институц болж бэхжээгүй, санхүүжилт нь тодорхой бус, зөвхөн сонгуулийн үеэр амилдаг. Тэгээд цаашдаа энэ олон улс төрийн намууд ингээд зөвхөн нэг сонгуульд зориулдаг ийм байдлаар цаашаа оршин тогтноход маш их бэрхшээлтэй.

Тийм учраас өнгөрсөн парламентын үед Монгол Улсын Ерөнхийлөгч энэ Улс төрийн намын хуулийг өргөн мэдүүлсэн. Тэгээд ажлын хэсэг байгуулагдаад, улс төрийн намууд зөвшилцөөд, бүлгүүд ярилцаад, энэ хуулийг хамтдаа зөвшилцсөний эцэст гаргасан. Тэгээд Улс төрийн намын хуулиа хэрэгжүүлээч ээ, та нар энэ шинэ хуулийнхаа дагуу шинээр бүртгүүлэх ажиллагаагаа зохион байгуулаач ээ гэхээр эхнээсээ авхуулаад ингээд одоо энэ чинь улам нэмэгдээд байгаа байхгүй юу. Одоо бараг 12 нам шаардлага өгчхөөд байна шүү дээ. Зөвхөн парламентад суудалтай намуудыг нам гэж үзэж болохгүй. Та нар бидний үг хэлэх, сонгох, сонгогдох эрхэд халдаж байна. Та нар шиг ингээд төрөөс санхүүжилт аваад үйл ажиллагаагаа явуулахад бидэнд бэрхшээлтэй байна.

Тэгээд бид нарт тодорхой хугацаа өгчихвөл наад дүрэмдээ шинэчилсэн зохион байгуулалтуудаа хийгээд явъя. Сая Орон нутгийн сонгууль болчихлоо. Их Хурлын сонгууль болчихлоо. Ингээд ийм богино хугацаанд бид нар амжихгүй байна. Шинэ хууль чинь тавигдах шаардлага нь өндөр байна л гээд ийм шаардлага тавиад байгаа юм. Хэрвээ бид энэ дагаж мөрдөх журмын хуулийн нөхцөл хангуулж, энэ үүрэгжүүлсэн заалт дээр сунгалтыг хийхгүй бол шинээр ер нь бүхий л улс төрийн намууд бүртгүүлэхэд хүнд болох юм байна лээ.

Тэгэхээр бид нар бас тэгж хатуурхаж бас болохгүй. Гэхдээ Улс төрийн намын хууль нэгэнт 01 сарын 01-нээс хэрэгжээд эхэлчихсэн юм чинь энэ үүрэгжүүлсэн заалтаа заавал хэрэгжүүл. Гол нь дагаж мөрдөх журмын хуулийн нөхцөл хангуулах тэр үүрэгжүүлж байгаа зөвхөн тэр дүрмийг бүртгэх хугацаа дээрээ тодорхой сунгалт хийе ээ гээд. Энэ нөгөө төрийн эрх барьж байгаа намын даргад, тэгээд хамтарсан Засгийн газарт ингээд шаардлага ирүүлээд байсан учраас Засгийн газраас энэ дээр бас тодорхой сунгавал байж болох уу гэдэг чиглэлээр хуулийг өргөн мэдүүлсэн.

Тэгээд энэ хууль өргөн мэдүүлсний дараа мэдээж, энэ ажлын хэсэг ажиллаад, ажлын хэсэг дээр энэ урт хугацаа байна. 12 сарын 31 хүртэл дүрмээ бүртгүүлэх хугацаа дээр нэг боломж олгоод, энэ хугацаанд хэрвээ энэ намын хуулийн босго шаардлагыг үүргийг биелүүлж чадахгүй бол дахиж сунгах, дахиж тэр намыг бүртгэх асуудал яригдахгүй. Тийм учраас энэ хугацаандаа хуулиа хэрэгжүүл гэдгийг бид нар улс төрийн намууддаа бас шаардах, шахах хэрэгтэй. Тэгээд сая бас гишүүдийн хэлж байгаагаар ирэх жилээс авхуулаад энэ Их Хурал дээр ч гэсэн энэ Улс төрийн намын хуулийг шинэ дүрмийн бүртгэлийг хийхтэй холбогдуулаад бэлтгэл ажлыг хангуулах дээр бас шахаж шаардаж ажиллах нь зөв байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Пүрэвдорж гишүүн суудалдаа сууя, суудалдаа сууя.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

10.33 цаг

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Эцэслэн батлуулах хуулийн төслийн хувилбарыг Төрийн байгуулалтын байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байгаа.

Санал хураалт.

1. Байнгын хорооны саналаар Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Ирц хангалттай байгаа. Санал хураалт.

Батлут гишүүн. Дэмжиж санал өгсөн гишүүд нэмж тэмдэглүүлэх юм уу? Батнайрамдал, Батжаргал, Батцэцэг, Батлут, Ж.Бат-Эрдэнэ, О.Алтангэрэл, Ж.Бат-Эрдэнэ гишүүн биш байна тийм ээ, О.Алтангэрэл Р.Батболд гэсэн 6 гишүүн дэмжсэнээр нэмж бүртгүүлэх нь байна.

Нийт 87 гишүүн дэмжсэн байна. 82,5 хувиар төхөөрөмж дээр бүртгэгдсэнээр санал дэмжигдлээ.

10.35 цаг

Ж.Бат-Эрдэнэ гишүүн горимын санал. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний микрофон өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ орж ирсэн төслөөрөө 2 дугаар зүйл дээр энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө өө гэсэн байсан юм. Тэгээд хугацааг бид нар сая батлахдаа 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс гээд ингээд арай хойшлуулчхаж байгаа юм.

Тийм болохоор эцсийн найруулгыг сонсьё гэсэн ийм санал гаргаж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Санал юм байна, тийм ээ. Горимын санал биш санал гаргаж байгаа юм байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос хуулийн эцсийн найруулгыг сонсох талаар санал гаргалаа.

Ингээд хуулийн төсөл эцэслэн батлагдсан.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан саналын дагуу батлагдсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

1. Улс төрийн намын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Одонгийн Цогтгэрэл гишүүн эцсийн найруулга дээр санал хэлье.

О.Цогтгэрэл: Намын тухай хуулийг хугацааг сунгах хууль эцэслэн батлагдлаа. Ер нь энэ ардчилсан парламент тогтолцооны амин сүнс нь улс төрийн намууд гэдэг нь эргэлзээгүй. Тэр тусмаа энэ улс төрийн намууд ялгаатай үзэл баримтлалтай, үзэл баримтлалынхаа дагуу бас үүрэг хариуцлагаа хүлээдэг энэ улс төрийн намууд байх нь энэ парламентын бас амин сүнс. Ер нь тэгээд яагаад ялгаатай байж, парламент дотор ялгаатай байр суурьтай улс төрийн хүчнүүд зэрэгцэн орших ёстой юм бэ? Яагаад бүгдээрээ нэг саванд очоод орчих ёсгүй юм бэ гэдэг асуулт бас үүний цаана зайлшгүй бас тавигдана.

Ер нь хөгжил дэвшлийн үндэс чин өөрөө өөрчлөлт юм гэнэ лээ. Өөрчлөлтийн үндэс чинь өөрөө хөдөлгөөн юм гэнэ лээ. Тэгэхээр тэр хөдөлгөөн гарах үндэс чинь ялгаатай л байдал. Тэгэхээр улс төрийн намууд бүгдээрээ нэг саванд ороод ялгаагүй болчихвол, тэр тусмаа дотоод үүрэг хариуцлага гэдэг олон зүйлүүд маань байхгүй болчихвол, энэ өөрөө парламентын тогтолцоонд энэ өөрөө улс үндэсний эрх ашигт харш гэж. Тэгээд энэ бүгдийг ярих болохоор улс төрийн намууд, олон

олон намууд бас хууль хэрэгжүүлмээргүй байна гэдэг энэ шаардлагыг тавьж байгаа нь үнэхээр бас харамсалтай.

Тэгээд үүний дагуу бас тодорхой хэмжээнд ингээд өөрчлөлтийн хугацаа орж байна. Ер нь бизнес ч гэсэн тэр хэрэглэгч өөрөө бараа бүтээгдэхүүн ялгаатай байж байж л хэрэглэгч нэг нь үнэтэй, нэг нь хямдхан, нэг нь чанартай, нэг нь баталгаатай, нэг нь илүү шинэхэн энэ ялгаатай бараа бүтээгдэхүүн.

Тэгэхээр бид бүгдийн хувьд яг өнөөдөр Монголын парламентад энэ намуудын ялгаатай болж дотоод цэгцрэлийг дэмжсэн Улс төрийн намын тухай хуулийг хойшлуулж байгаа гэдэг нэг ийм нөхцөл байдал бид бүгдийн хувьд байна. Тэгээд жилийн хугацаандаа намууд цэгцэрч, энэ зарчимгүй байдлаасаа хуулийг хэрэгжүүлмээргүй байна гэдэг энэ байдалдаа бас үнэхээр хамгийн гоё сайхан зүйлүүдийг л улс төрийн намууд л хэлдэг. Нийгэмд болохгүй, бүтэхгүй байгаа зүйлийг бид бүгд л шүүмжилдэг. Тэгчхээд бодит байдал дээрээ яг энэ дотоод цэгцрэл, олон олон зүйлээсээ энэ хойш суусан энэ энэ үйлдлийг дахин дахин ийм үйлдэл Монголын парламент дээр гарахгүй байгаасай. Энэ олдож байгаа нэг жилийн хугацааны хуулийн боломжийг бүрэн дүүрэн ашиглаж, тэр ярьдаг, хэлдэг гоё сайхан зүйлсээ бүгдээрээ бас үүрэг хариуцлагатай өөрсдөөсөө эхэлж хийцгээе л гэж хэлье. Энэ хууль ингээд эцэслэн батлагдаж байна.

Д.Амарбаясгалан: Очирбатын Амгаланбаатар гишүүн үг хэлье. Эцсийн найруулга дээр.

О.Амгаланбаатар: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Бид нарын хувьд сая ингээд төсөв хэлэлцээд бараг нэг сар гаруй явчихлаа. Тэгээд энэ төсөв данхайлаа, төсөв том байна, төрийн алба томорлоо гээд л яриад байдаг, яриад байдаг. Тэгээд үүний чинь цаад талын үндэс нь ерөөсөө л энэ нам болчихоод байгаа шүү дээ. Бүх сумд хөлтэй, 200 мянган гишүүнтэй гээд л яриад байдаг, яриад байдаг. Тэгээд энэ 200 мянган гишүүнээ ажилтай болгох, энэ 200 мянган гишүүнээ ард нь нэг чирч явах гэж л энэ төрийн алба чинь данхайгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ Улс төрийн намын тухай хуулиа улам сайжруулах зайлшгүй шаардлагатай байна. Одоо сая ингээд энэ Мөнхбаатар бүлгийн дарга хэлж байна. Нийтдээ 30 хэдэн нам, 20 хэдэн мянган гишүүнтэй болж байж бүртгүүлэх ийм юм руу орж байна.

Тэгээд ингээд бодоход бараг сая гишүүнийг, сая гишүүнчлэлтэй болж байж энэ улс төрийн Монгол Улсын бараг энэ сонгууль өгдөг бүх хүн намын гишүүн байж байж ингэж намууд бүрдэх нь л дээ, эргээд. Тэгэхээр бид нарын хувьд энэ Улс төрийн намын тухай хууль энэ хатуу гишүүнчлэлийнхээ асуудал дээр эргэж харахгүй бол болохгүй байгаа юм гэдгийг бас энд хэлье. Тэгээд ямар дүрэм байна, түүнд тааруулж л арга замаа сонгодог. Нэгэнт ингээд хатуу гишүүнчлэлийг ингээд сонгочихсон, нэгэнт Их Хуралд юм уу, аймгийн хуралд сонгогдохын тулд тэр гишүүд рүүгээ гэдэг юм уу, хөл гар луугаа ажиллахаас өөр замгүй болдог. Тэгэхээр энэ Улс төрийн намын тухай хуулийг улам сайжруулж байж, энэ төр цэгцэрнэ ээ, энэ төрийн алба чинь данхайхаа болино.

Тийм учраас энэ Улс төрийн намын тухай хууль бол хамгийн чухал хууль байгаад байгаа юм. Монгол Улс бол тийм шашин хоорондын янз бүрийн мөргөлдөөн байхгүй, бараг энэ нам хоорондын мөргөлдөөнтэй болчихлоо шүү дээ. Өнгөрсөн

сонгуулиар юу болов. Өвөрхангайд. Чи АН ярьдаг хүн гэж хэлээд нэгийгээ алсан тохиолдол л анх удаагаа гарч байна шүү дээ. Хойшоо хойшид энэ асуудал улам даамжирна. Намаас болж хүн алсан ийм зүйл Монгол Улсад гараад ирж байгаа.

Тийм учраас энэ Улс төрийн намын тухай хуулийгаа улам сайжруулахгүй бол энэ нэг сум дотор ах дүү нар хүртэл хоорондоо бие биеэ үзэж чадахаа больчихсон ийм зүйл чинь энэ Улс төрийн намын тухай хуулиас л болоод байгаа шүү дээ. Тэгэхээр энийг улам сайжруулах ийм шаардлагатай байгаа шүү гэдгийг энд хэлье. Та бүхэнд.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр намайг нэг сүүлийн үед энэ том том төсөл хөдөлгөнө, хамтарсан засаг жоохон явах ёстой гэхээр яг тэрийг бүрэн дүүрэн дэмжээд байна гэж ойлгоод байж болохгүй. Яагаад гэвэл энэ Монгол Улсад өөрчлөх ёстой олон олон зүйлүүд байгаа. Ялангуяа манай хамтарсан засагт орсон 8 сайд, түүн дотроо олон олон асуудалтай яамнууд байж байгаа. Өнгөрсөн хугацаанд маш их олон хулгай явсан. Нүүрсний хулгай гэхэд 44 их наядын хохиролтой. Энэ их олон хулгайнуудыг хийхдээ улс төрч нарын удирдлага доор, хуулийнхны хамгаалалт дотор хийсэн байхгүй юу. Тийм учраас өнөөдөр Алтангэрэл сайд гэхэд ямар ч тийм өөрчлөлт хийж чадахгүй ингээд сууж байна. Сайдыг нь өгсөн боловч доор нь тэр, агентлаг, яам, Тамгын газарт өөрчлөлт хийх тэр боломжийг нь ерөөсөө олгохгүй байгаа.

Дээрээс нь өнөөдөр Ардын намын сайд нар бол яг өнгөрсөн хугацаанд хулгай хийсэн тэр бүх хүмүүсээ бүгдийг нь хамгаалсан хэвээрээ л байгаа. Төрийн өмчийн томоохон компаниуд тэр чигээрээ хулгай зэлгий бүх зүйлийг хийж байсан. Тэр бүх зүйл дээрээ та нар энэ хамтарсан засаг гэдэг энэ шалтгаанаараа тэр бүх өөрчлөлтийг хий л дээ. Нам дотор шинэ мотивац бий болго л доо, өөрсдийнхөө, МАН дотроо. Тэр олон олон хулгайч нарыг бүгдийг нь соль л доо. Энэ ажлуудыг ерөөсөө хийхгүй.

Тэгээд л ерөөсөө 1 тийм нэг компанийн захирал тэр том төрийн том компанийн захирал нэг том албан тушаалтныг тэвэрчихсэн, тэр тэврэлтээс нь та нар нөгөөдхөө хамгаалаад ерөөсөө салгахгүй байна шүү дээ. Ийм нөхцөл байдалтай л байгаа шүү дээ. Дандаа нэг тийм хуучинсаг нөхөд бүгдээрээ оччихсон. Өнөөдрийн энэ шинэ нөхцөл байдал, шинэ орчинд нийцэхгүй тийм нөхдийг бүгдийг нь өнөөдрийг хүртэл байлгаад л тэгээд л нэг тийм юу байдаг юм. Би геологич хүн геологийнхоо салбарыг мэдэж байна гээд л ерөөсөө хуучинсгаар асуудалд хандаад ерөөсөө бүх зүйлийг урагшаа явуулахгүй ийм нөхцөл байдалтай байгаад байна шүү дээ.

Тийм учраас энэ шинэ он гарч байна. Жоохон өөр нөхцөл байдлаар та нар ажиллаач ээ, энэ хүмүүсээ солиоч ээ. Өнгөрсөн хугацаанд та нар танай Ардын намд 8 жилийн туршид тэр дунд шатад, дээрээс нь төрийн өмчийн компаниудыг хулгай хийсэн тэр хүмүүсээ үүгээр нь өөрчилж ав л даа. Ингэж байж шинэ салхи та нарт орно.

Дээрээс нь манай тэр АН-ын нөхөд бас олон олон шинэлэг бодолтой тэр хүмүүс төрд орж бас тодорхой хэмжээний энэ харилцан хяналттай байх тэр бүх зүйлүүдийг чинь бүгдийг нь хийх ёстой байхгүй юу даа. Ийм юм ерөөсөө хийхгүй, ЗГ

тэгчхээд нэг 8 сайд тавьчхаад л тэгээд л өө, ингээд боллоо гэдэг байдлаар ийм асуудалд хандах юм бол манай нам энэ хуулиар асуудал шийддэг нам биш ээ. Манай нам бол хуультай хуульгүй намынхаа даргыг шийдээд, цаашаа ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Эцсийн найруулга дээр Гонгорын Дамдинням гишүүн үг хэлье. Эцсийн найруулгатай холбоотой үг хэлмээр байна. Улс төрийн мэдэгдлүүд хийгээд байх юм.

Г.Дамдинням: Энэ манай АН дотор даргын сунгаа өрнөчхөөд хэцүү байх шиг байна, тийм. Тэгээд манай АН-ынхан даргынхаа сунгаанд эртхэн бэлдэцгээгээд, зодоглоцгоогоод ажил сайн явуулахгүй, мануусыгаа ирж гөвөөд байх юм. МАН-д энэ намыг энэ намын хуулийг нэг жилээр сунгах ямар ч хэрэгцээ байхгүй шүү дээ. Та нарын гуйлтаар л хийж байгаа гэж ойлгож байгаа. Хамтарсан Засгийн газрыг бас нэг ажлаа хийг, Монголын ард түмэнд хэрэгцээтэй ажлуудыг хийг, том том төслүүдээ явуулаг гэж манай нам тулхтай, түшигтэй, алсын хараатай учраас та нарыг бас яах вэ дээ л гэж байгаа шүү дээ, манай намын бүлэг.

Тэгэхээр та нар бас бид нар луугаа багахан шиг дайрч үзээрэй дээ. Хамтарч байгаа бол хамтарсан шиг байгаарай. Бид нар бас тэвчээр гаргаж байгаа. Дуугүй сууж байгаа шүү. Тэгэхээр Улс төрийн намын тухай хууль нэг жилийн хугацаатайгаар суналаа. Энэ хугацаанд хурал, зөвлөгөөнөө аятайхан хийгээд, төр, улс, ард түмнийхээ төлөө өргөсөн тангаргаа бодоод, дотроо бага шиг алалцаад, урагшлахаа бодоорой. Энэ хуулийг дахиж сунгахгүй шүү гэсэн байр суурьтай байгаагаа илэрхийлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.45 цаг

Өнөөдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулган хэлэлцэх асуудал ингээд дуусаж байгаа.

Ирэх 7 хоногоос эхлээд Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн хурлыг ажлын 5 өдөрт олон давтамжтайгаар зохион байгуулж эхлэхээр өнөөдөр Даргын дэргэдэх зөвлөл дээр ирэх 7 хоногийн чуулганы хуваарь гарч байгаа.

Тэгэхээр ажлын хэсгийн дарга нар тодорхой хуулийн төслүүд дээр ажиллаж байгаа ажлаа эрчимжүүлэх, хамгийн чухлаас нь эхлээд хууль тогтоомжийн хуулийг нэмэлтийг өргөн барих, нэмэлт, өөрчлөлтийг өргөн барих, Булгантуяа гишүүнээр ахлуулсан төсвийн хэлэлцүүлэгтэй холбоотой олон хуулиудын цаглаврыг жигдлэх, давхардлыг арилгах, төсөв хэлэлцэх процессыг илүү нарийвчилж, ээдрээ төвгийг нь багасгах чиглэлүүд дээр нэлээн ажиллах шаардлагууд байгаа.

Сая энэ Бөхчулууны Пүрэвдорж гишүүний хэлсэнчлэн энэ төрийн өмчийн компаниудыг эмхэлж, цэгцлэх асуудлаар Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн ахалсан ажлын хэсэг байгуулагдсан. Төр аж ахуйн үйлчилгээний бизнесийг хийхгүй байх чиглэл дээр бас Улсын Их Хурлын гишүүд орж ажиллаж байгаа.

Чанар, стандарт шаардлагатай холбоотой асуудлуудыг тодорхой болгох чиглэл дээр Батнайрамдал гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна.

Зөвшөөрлийн хууль, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хууль зэргийг манай Хассуурийн Ганхуяг гишүүн ахлаад ажиллаж байна.

Тэгэхээр эдгээр ажлын хэсгүүд маань ажлын хэсгийнхээ үйл ажиллагааг эрчимжүүлээд, хуулийн нэмэлт, өөрчлөлтийнхөө төслүүдийг боловсруулж оруулж ирэх дээр анхаармаар байгаа юм.

Ялангуяа Энхтүвшин гишүүн энэ олон төрийн өмчит компани нэг талдаа төрд ашиггүй, нөгөө талдаа нийгэмд хэрэгцээгүй, тэгсэн мөртөө төрийн өмчит компани гэсэн статустай явж байгаа энэ байдлуудыг ер нь эмхэлж, цэгцлэх ажил руу Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсгийнхээ хүрээнд өргөн хүрээгээр орж Засгийн газартай хамтарч ажиллах ийм шаардлага бас байгаа.

Тэгэхээр та бид энэ асуудлыг 3, 4 сарын хугацаанд ярилаа шүү дээ. Одоо бүгдээрээ ажил болгоцгооё. Гишүүд идэвхтэй ажилла.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулж өгсөн ажлын хэсгийн гол зорилго бол энэ олон гишүүд маань өөрсдийн харж байгаа өнцөг, хүсэж байгаа тэр өөрчлөлт, шинэчлэлтийг хийх боломжийг нь гаргаж өгөх зорилготой учраас энэ ажлын хэсгийг та бүхэн минь идэвхтэй авч ажиллаарай гэдгийг та бүхэндээ хэлье.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөж байна.

10.47 цаг

17 цагаас гишүүдийн сургалттай. Цагтаа очихыг хүсье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ *П.ОЮУНГЭРЭЛ*